

Дундговь аймгийн Засаг даргын Монгол улсын засгийн газрын гишүүн Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдтай 2023 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

2023 оны 12 дүгээр сарын 14

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж хэрэгжилт удаашралтай арга хэмжээний жагсаалтыг гарган холбогдох хэлтэст хүргүүлэн цаашид анхаарах асуудал дээр өгч ажилласан.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН


Аймгийн Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 38 үүргийг хүлээж, үүргийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнг тооцож ажилласнаар жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 95.3 хувьтай байна.

Хүлээсэн үүргээс “Органик түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, баталгаажуулалтын байгууллагыг байгуулах ажлыг эрчимжүүлэх, шинээр байгуулах” гэсэн арга хэмжээний хүрээнд 2023 оны 3 сард зохион байгуулсан Мэргэжилтний зөвлөгөөнөөр Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны ХҮБХЗГазрын Органик хүнс хариуцсан ахлах мэргэжилтэн Д. Тунгалаг “Органик

түүхий эд бүтээгдэхүүн, хамтын баталгаажуулалтын байгууллага"-ыг хэрхэн байгуулах талаар мэдээллийг" Хүнс, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд, үйлдвэрлэгчид зэрэг 120 хүнд мэдээлэл сургалт өгсөн.

Үйлдвэрлэгчдээс баталгаажуулалтын байгууллага болох санал хүсэлт ирээгүй учраас 0 үнэлгээ өгсөн.

Хэрэгжилтийг графикаар харуулбал:



ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:


Улсын төсөв, орон нутгийн хөгжлийн сан, малчдын хувь хөрөнгөөр 45 шинээр, 48 энгийн уурхайн худгийг сэргээн засварласан байна. Нийт 72,0 мянган га бэлчээрийн талбайг усжуулж, өмнөх оноос 0,7 хувиар бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлж малчдыг дэмжиж хамтран ажилласан байна.



Таваарын буюу хэрэгцээний 848640 малаас 472877 малыг зах зээлд борлуулж эдийн засгийн эргэлтэд оруулсан байна. ХХААХҮЯам, аймгийн ХХААГ-тай хамтран зохион байгуулсан "Өвлийн идэш арга хэмжээнд тус аймгийн 12 сумын 63 малчин 278 тн мах худалдан борлуулж улсдаа тэргүүлэн ажиллалаа. Энэ нь манай аймгийн малын махны амт чанартай холбоотой гэж үзэж байна.




Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөн "Хүнсний хангамж аюулгүй байдал"-ын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны санхүүжилтээр 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хүнс хөдөө аж ахуйн газрыг түшиглэн Жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийг 3 га талбайд байгуулсан байна.



2022 онд батлагдсан УИХ-ын 36 дугаар тогтоолд дотоодын үйлдвэрлэлээр хүн амын хүнсний хэрэгцээг хангахаар заасан, хүнсний нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн аж ахуй нэгжийг урамшуулж, дэмжлэгт тус аймгаас 2 ААН-ийг 350,0 сая төгрөгийн, ХХААХҮЯамнаас хэрэгжүүлж буй хүнсний үйлдвэрлэлийг дэмжих "Хөрөнгө оруулалт"-ын хөнгөлөлттэй зээлд дэмжлэгт хамруулж үйлдвэрлэлээ өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх зээлд Мандалговь Хүнс ХХК 245.0 сая, төгрөгийн санхүүжилтийг авч ажилласан зэрэг иргэд аж ахуй нэгжүүдийг хөнгөлөлттэй зээл тусламжид хамруулахад санаачилга гарган ажилласан байна.

Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх орон нутагт нарийн ногооны хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр Сайнцагаан сумын Мөнгөлөг МД ХХК нь 179.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна.



Аймгийн тогооч нарын зөвлөгөөн, сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж хувийн хэвшил болон сургууль цэцэрлэгийн 80 тогооч нарыг тус тус хамруулан зохион байгуулсан.



Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага "Жайка ОУБ"-ын хэрэгжүүлж буй үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих төслийн хүрээнд Сайнцагаан сумын 2 сургуульд тоног төхөөрөмж нийлүүлэгдэж сургуулийн үдийн хоолны хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын тогтолцоо бүрдэж, орчин нөхцөл сайжирсан байна. Энэ хүрээнд Сайнцагаан сумаас сонгогдсон "Мандал", "Говийн Ирээдүй" сургуулийн үдийн хоолны хангамжид төмс, хүнсний ногоо нийлүүлэх 10 ногоочинд танхимын болон талбайн сургалтыг зохион байгууллаа.



Мал аж ахуй орлогын албан татвараас сум бүр 1,357.6 сая төгрөгийг төвлөрүүлэн хөдөө аж ахуйн салбарын 5-н арга хэмжээнд зарцуулан ажилласан бөгөөд 1 арга хэмжээ болох аймгийн мал, аж ахуйн салбарын дунд хугацааны 2024-2033 он хүртэл хэрэгжүүлэх 11 зорилт, 7-н бүлэг, арга хэмжээтэй мал аж ахуйн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 06 сарын 27-ны өдрийн 28 дугаар тогтоолоор хэлэлцүүлэн батлуулж 2024 оноос эхлэн хэрэгжүүлж ажиллана.



Азийн 14 улсын Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний онлайн ФлатФорум үүсгэх зорилгоор орон нутгийн брэнд болох хонь, ямааны мах, ямааны сүү, гүүний айраг, хөмүүл, таанын нарийвчилсан 80 дээжийг олон улсын байгууллагын лабораторид судлуулахаар судалгааны дээжийг хүргүүлэн ажиллаж байна.



Аймгийн хэмжээнд 4 суманд дахивар цэг шинээр нэмэгдэж байгуулагдаж, аймгийн хэмжээнд дахивар цуглуулах 7 цэгтэй болсноор нийт 81 тн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж дахивар авах цэгт цуглуулсан. Үүнээс дахин боловсруулах үйлдвэрт 40 тн дахивар нөөц тушаасан.



2023 оны орон нутгийн хөгжлийн 18.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус бүр 1 тонн даацтай, өөрөө буулгагч, шатахуун зарцуулалт бага, дахивар зөөвөрлөх гурван дугуйт тээврийн хэрэгсэл 2 ширхгийг авч Мандлын гэгээ Хот тохижуулах газар, "Баялаг төв"-д хүлээлгэн өглөө.



Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас энэ онд 11 аж ахуйн нэгж байгууллагад 1,199.4 сая төгрөгийн зээл олгож үүний үр дүнд жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн тоо өмнөх оноос 11 -ээр нэмэгдэж хадгалагдсан ажлын байр-21, шинээр 22 ажлын байр бий болсноос гадна сангийн зээлийн хэмжээ 979.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний уул уурхайн салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 95.3 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд 8,050.2 сая төгрөгийг зарцуулан хэрэгжүүлсэн байна. Үүнд улсын төсөв 2,562.5, орон нутгийн төсөв 3,978.4 сая, байгууллагын төсөв 2.5 сая, төсөл хөтөлбөр 73.9 сая, хандив тусламж, бусад 1,432.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь гэрээгээр хүлээсэн үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд нөлөөлсөн гэж үзлээ.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст:

Гэрээнд тусгагдсан үүргийн хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшнийг бодитой судалгаанд үндэслэн тодорхойлох

Гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн талаар аймгийн удирдлагуудыг тогтмол хугацаанд мэдээллээр хангаж, хэрэгжилт удааширсан болон тасарч болзошгүй заалтыг эрчимжүүлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллаж байх

Хүнс хөдөө аж ахуйн газарт:

Аймгийн Засаг даргын гэрээгээр хүлээсэн үүргийг хэрхэн хэрэгжүүлж ажиллаж байгаа талаар албан хаагчдынхаа ажлын мэдээллийг сонсон эрчимжүүлж ажиллаж байх

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу хийж хэрэгжүүлж байгаа ажлыг иргэдэд сурталчлах мэдээлэх ажлыг тогтмолжуулах

Тайланг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу хүрэх түвшинд хүрсэн эсэхийг тайлагнахаас гадна үр дүн, үр нөлөөний талаар тайлагнаж хэвших мөн нотлох баримтыг тайланд хавсаргаж ирүүлж байх

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн



[Signature] Н.Мөнхбат

[Signature] Д.Даариймаа

[Signature] Э.Одончимэг